



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 9 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар: 343

Улаанбаатар хот

**ОЛИМП, НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
БҮРЭЛДЭХҮҮН, ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ, САЙДЫН АЖЛЫН АЛБАНЫ
ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 34² дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дүрмийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны буюу Монгол Улсын сайдын Ажлын албаны орон тооны хязгаарыг 5 байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоолын 2-т заасан Ажлын албаны 2022 оны үйл ажиллагааны зардалд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2022 оны батлагдсан төсвийн багцийн хүрээнд зохицуулан санхүүжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд, цаашид зохих журмын дагуу тооцож холбогдох төсөвт тусгахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

**ОЛИМП, НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга:

- Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга

Гишүүд:

- Батлан хамгаалахын сайд;
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
- Боловсрол, шинжлэх ухааны сайд;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;
- Барилга, хот байгуулалтын сайд;
- Соёлын сайд;
- Цахим хөгжил, харилцаа холбооны сайд,
- Эрүүл мэндийн сайд;
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын нутгийн удирдлагын бодлого хариуцсан дэд дарга;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх (тохиролцсоноор);
- Улсын Их Хурлын даргын зөвлөх (тохиролцсоноор);
- Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дарга;
- Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн захирал;
- Монголын Үндэсний олимпын хорооны ерөнхийлөгч (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга:

- Биеийн тамир, спортын улсын хорооны дарга

ОЛИМП, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмээр Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хороо(цаашид "Хороо" гэх)-ны үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Хороо нь нийтийн биеийн тамир, мэргэжлийн спортыг хөгжүүлэх, үндэсний уламжлалт спортыг дэмжих, хөгжүүлэх, биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхэд Монгол Улсын сайдад дэмжлэг үзүүлэх, олимпизмыг дэлгэрүүлэх, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх замаар эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, иргэдийн хүмүүнлэг, эрүүл чийрэг, бүтээлч чанарыг хэвшүүлэх үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1.3.Хороо нь үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг удирдлага болгоно.

1.4. Хорооны ажлын албаны үүргийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 342 дугаар зүйлийн 2-т заасны дагуу Монгол Улсын сайдын Ажлын алба (цаашид "Ажлын алба" гэх) хэрэгжүүлнэ.

1.5.Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга тогтоосон журмын дагуу үйлдсэн Үндэсний хорооны тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр.Хорооны зохион байгуулалт

2.1.Хороог Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга (цаашид "Монгол Улсын сайд" гэх) тэргүүлж, үйл ажиллагааг удирдлагаар хангана.

2.2.Хорооны гишүүн, нарийн бичгийн дарга нь орон тооны бус байна.

2.3.Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Хорооны хуралдаан байна.

2.4.Хорооны ээлжит хуралдааныг улирал бүр хийнэ. Шаардлагатай тохиолдолд Монгол Улсын сайдын санаачилгаар ээлжит бус хуралдааныг хуралдуулж болно.

2.5.Хорооны хуралдааныг Монгол Улсын сайдын санаачилгаар төрийн болон төрийн бус байгууллага, спортын мэргэжлийн холбоод, эрдэмтэн, судлаач, хувийн хэвшлийн, олон улсын байгууллагын төлөөллийг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулж болно.

2.6.Хорооны нийт гишүүдийн ердийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.7.Хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.8.Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар тогтоол, зөвлөмж гаргах бөгөөд түүнд Монгол Улсын сайд, хорооны нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

2.9.Хорооны хуралдааны тэмдэглэлийг хөтөлж баталгаажуулах бөгөөд түүнд хорооны нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

2.10.Хорооны хуралдааны дэгийг Монгол Улсын сайд батална.

Гурав.Хорооны дарга, гишүүний эрх, үүрэг

3.1.Монгол Улсын сайд дараахь эрх, үүрэгтэй

3.1.1.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан Засгийн газрын гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

3.1.2.Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах;

3.1.3.хорооны бүрэлдэхүүнийг Засгийн газарт санал болгох;

3.1.4.хорооны ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг баталж, хуралдааныг товлох, даргалах;

3.1.5.хорооны хуралдаанаас гарсан тогтоол, зөвлөмжид тусгагдсан асуудлыг холбогдох хууль, журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

3.1.6.хороог дотоод, гадаадад төлөөлөх;

3.1.7.хорооны гишүүдэд үүрэг, даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавих;

3.1.8.хорооны үйл ажиллагааны тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

3.1.9.Ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой журам, заавар баталж мөрдүүлэх;

3.1.10.Ажлын албаны дарга, бусад ажилтныг томилж, чөлөөлөх, ажилтнуудын ажил, үүргийн хуваарийг батлах;

3.1.11.хуульд заасан бусад эрх.

3.2.Хорооны гишүүн дараахь эрх, үүрэгтэй:

3.2.1.хорооны хуралдаанд биечлэн оролцож, шийдвэрлэх асуудлаар санал оруулах, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд Ажлын албанд албан ёсоор мэдэгдэж, хуралдаанаар хэлэлцэх асуудалд бичгээр санал өгөх;

3.2.2.хорооны шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнтэй танилцах, хариуцсан чиглэлийн дагуу зөвлөгөө өгөх, тавьсан санал, хүсэлтийг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, хяналт тавих;

3.2.3.хорооны даргын өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх, ажлын тайлангаа хороонд тайлагнах;

3.2.4.хариуцсан чиглэлийн дагуу Хороонд холбогдох мэдээ, тайлан, статистик тоо баримт гаргаж өгөх;

3.2.5.хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай танилцах, хорооноос хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах.

3.3.Монгол Улсын сайдын түр эзгүйд эрх, үүргийг түүний томилсон хорооны гишүүн хэрэгжүүлнэ.

Дөрөв.Сайдын Ажлын алба

4.1.Хорооны өдөр тутмын үйл ажиллагааг Монгол Улсын сайдын Ажлын алба хэрэгжүүлнэ.

4.2.Ажлын алба дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.2.1.хорооны жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах;

4.2.2.Монгол Улсын сайдын эрхлэх асуудлаар хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, холбогдох албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

4.2.3.Монгол Улсын сайдын эрхлэх асуудлаар Засгийн газрын хуралдаанд танилцуулах, хэлэлцүүлэх асуудлын материалыг холбогдох журмын дагуу бэлтгэх;

4.2.4.Монгол Улсын сайд, хорооны гишүүдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

4.2.5.хорооноос гаргасан тогтоол, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах;

4.2.6.хорооны үйл ажиллагаанд шаардагдах тайлан, мэдээ, статистик тоо баримт, лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулах, бэлтгэх, мэдээллийн сан бүрдүүлэх;

4.2.7.хорооны хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах, Хорооны шийдвэрийг албажуулан гаргаж, Хорооны гишүүд, холбогдох байгууллагад хүргүүлэх;

4.2.8.хорооны үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах;

4.2.9.хорооны албан хэрэг хөтлөлтийг зохих журмын дагуу эрхлэх, хадгалах, хамгаалах асуудлыг хариуцах.

4.3.Ажлын албаны дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.3.1.Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

4.3.2.Монгол Улсын сайдаас олгосон бүрэн эрхийн хүрээнд Ажлын албаны хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх;

4.3.3.хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гарган Монгол Улсын сайдаар батлуулах, хорооны шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.3.4.Ажлын албаны төсвийг тайлагнах, шилэн данс хөтлөх ажлыг зохион байгуулах.

4.4.Ажлын албаны дарга, орон тооны ажилтан нь төрийн улс төрийн албан хаагч байна.

Тав.Хорооны үйл ажиллагааны зардлын санхүүжилт

5.1.Хороо, түүний Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Зургаа.Бусад зүйл

6.1.Хороо нь монгол, англи хэлээр өөрийн зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай мэдээллийг харуулсан албан ёсны цахим хуудастай байна.

6.2.Хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбоотой төрийн болон албаны нууцад хамаарах асуудлыг задруулах, хуралдааны шийдвэр баталгаажих хүртэл аливаа мэдээллийг бусдад тараахыг хориглоно.

6.3.Хорооноос гаргасан шийдвэрийг төрийн бусад байгууллага холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтийг хангах чиглэлээр дотоод зохион байгуулалтын арга хэмжээ авах, ажлын уялдаа холбоог хангаж хамтран ажиллах үүрэгтэй.

---oOo---